

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/210/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН МУЗЕЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Г.Баянжаргал

Утас: 70273204 Цахим хаяг: bayanjargalg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт.....	18
4.1 Залруулсан алдаа	18
4.4 Зөвлөмж.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
НХМ	Нэг хэвийн маягт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОБГ	Онцгой байдлын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

11100 Зууныот, Төв аймаг
Утас: 70272248, Факс: 70272582, И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/94
Танай _____ -ийн № _____ -т

ТӨВ АЙМГИЙН МУЗЕЙН
ЗАХИРАЛ Б.СҮХБААТАР ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц ХИШИГЖАРГАЛ

19020320

D 2022/2022 он/ALBAN BICHIG

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		/Төгрөгөөр/	
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	26,419,458.50	25,911,098.50
35	БАРАА МАТЕРИАЛ	26,419,458.50	25,911,098.50
354	Хангамжийн материал	26,419,458.50	25,911,098.50
35410	Бичиг хэргийн материал	561,550.00	1,438,150.00
35420	Аж ахуйн материал	16,260,810.00	15,399,490.00
35440	Түлш, шатах тослох материал	203,840.00	153,000.00
35470	Бусад хангамжийн материал	9,393,258.50	8,920,458.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,074,045,832.05	1,102,466,315.55
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,074,045,832.05	1,102,466,315.55
392	Биет хөрөнгө	1,023,855,832.05	1,052,324,315.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	544,434,013.00	598,218,223.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-459,091,097.22	-502,440,847.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	27,000,000.00	27,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-9,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	32,020,384.15	32,695,384.15
39206	Хуримтлагдсан элэгдэл	-14,148,762.93	-21,426,573.74
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,476,540.00	39,476,540.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17,610,474.95	-22,340,690.90
39209	Зам, гүүрийн байгууламж	00.00	28,714,600.00
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	870,575,480.00	876,437,880.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,199,750.00	5,229,750.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-239,949.96
393	Биет бус хөрөнгө	50,190,000.00	50,142,000.00
39301	Програм хангамж	290,000.00	290,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-50,000.00	-98,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	49,950,000.00	49,950,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,100,465,290.55	1,128,377,414.05
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,100,465,290.55	1,128,377,414.05
51	Засгийн газрын хувь оролцоо	1,100,465,290.55	1,128,377,414.05
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	402,382,470.00	402,382,470.00
51101	Өмч: - төрийн	402,382,470.00	402,382,470.00
512	Хуримтлагдсан үр дүн	-175,495,330.29	21,480,932.01
51210	Өмнөх үеийн үр дүн	-175,495,330.29	-6,431,191.49
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	27,912,123.50
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	873,578,150.84	704,514,012.04
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,100,465,290.55	1,128,377,414.05

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	302,037,600.40	356,137,431.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	46,168,000.40	101,928,331.00
120	Нийтлэг татварын бус орлого	46,168,000.40	101,928,331.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	46,168,000.40	101,868,331.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,804,500.00	3,486,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	42,363,500.40	98,442,331.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	255,869,600.00	254,209,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	1,000,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчиг бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	1,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	255,869,600.00	253,209,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	255,869,600.00	253,209,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	278,434,412.08	325,032,522.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	278,434,412.08	325,032,522.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	265,650,243.60	316,033,582.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	169,840,427.05	174,413,940.52
210101	Үндсэн цалин	169,840,427.05	118,190,446.83
210102	Нэмэгдэл	00.00	43,084,493.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	13,139,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,488,945.01	22,990,087.54
210201	Тэтгэврийн даатгал	19,230,746.06	15,998,231.28
210202	Тэтгэмжийн даатгал	564,549.70	1,757,414.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	451,639.79	1,395,851.20
210204	Ажилгүйдлийн даатгал	112,909.89	348,962.73
210205	Эрүүл мэндийн даатгал	1,129,099.57	3,489,628.19
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,943,321.00	39,659,882.00
210301	Гэрэл, цахилгаан	3,483,757.00	3,275,732.00
210302	Түлш, халаалт	37,882,504.00	35,112,055.00
210303	Цэвэр, бохир ус	577,060.00	1,272,095.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,380,700.46	2,896,290.00
210401	Бичиг хэрэг	734,734.00	405,500.00
210402	Тээвэр, шатахуун	663,092.00	624,940.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	605,074.46	599,220.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	72,800.00	1,266,630.00
2105	Нормативт зардал	754,530.00	472,450.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	754,530.00	472,450.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,936,750.00	2,963,780.00
210604	Урсгал засвар	2,936,750.00	2,963,780.00
2107	Томилголт, зочны зардал	669,000.00	416,000.00
210702	Дотоод албан томилголт	669,000.00	416,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,301,250.00	6,207,090.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,558,700.00	5,464,540.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	50,000.00	50,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,700.00	110,700.00
210807	Газрын төлбөр	149,850.00	149,850.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,335,320.08	66,014,062.74
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,335,320.08	66,014,062.74

Төв аймгийн Музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,784,168.48	8,998,939.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,515,000.00	1,824,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,335,000.00	1,424,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	180,000.00	400,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,269,168.48	7,174,939.94
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,269,168.48	7,174,939.94
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	23,603,188.32	31,104,908.26
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	3,192,784.76
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	3,192,784.76
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-3,192,784.76
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	23,603,188.32	27,912,123.50

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	259,674,100.00	257,695,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,804,500.00	3,486,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,804,500.00	3,486,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,804,500.00	3,486,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,804,500.00	3,486,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	255,869,600.00	254,209,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	1,000,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	1,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	255,869,600.00	253,209,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	255,869,600.00	253,209,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	259,674,100.00	257,020,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	259,674,100.00	257,020,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	246,889,931.52	248,021,160.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	169,840,427.05	174,413,940.52
210101	Үндсэн цалин	147,230,167.44	118,190,446.83
210102	Нэмэгдэл	13,306,797.61	43,084,493.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,303,462.00	13,139,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,488,945.01	22,990,087.54
210201	Тэтгэврийн даатгал	19,230,746.06	15,998,231.28
210202	Тэтгэмжийн даатгал	564,549.70	1,757,414.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	451,639.79	1,395,851.20
210204	Ажилгүйдлийн даатгал	112,909.89	348,962.73
210205	Эрүүл мэндийн даатгал	1,129,099.57	3,489,628.19

Төв аймгийн Музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,943,321.00	39,659,882.00
210301	Гэрэл, цахилгаан	3,483,757.00	3,275,732.00
210302	Түлш, халаалт	37,882,504.00	35,112,055.00
210303	Цэвэр, бохир ус	577,060.00	1,272,095.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,428,038.46	2,180,320.00
210401	Бичиг хэрэг	1,622,064.00	542,600.00
210402	Тээвэр, шагахуун	595,900.00	558,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	605,074.46	599,220.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	305,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	300,000.00	300,000.00
2105	Нормативт зардал	987,000.00	1,376,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	987,000.00	1,376,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,913,250.00	2,267,280.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	297,000.00
210604	Урсгал засвар	3,913,250.00	1,970,280.00
2107	Томилолт, зочны зардал	669,000.00	416,000.00
210702	Дотоод албан томилолт	669,000.00	416,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,619,950.00	4,717,150.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,877,400.00	3,974,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	50,000.00	50,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,700.00	110,700.00
210807	Газрын төлбөр	149,850.00	149,850.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,784,168.48	8,998,939.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,515,000.00	1,824,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,335,000.00	1,424,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	180,000.00	400,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,269,168.48	7,174,939.94
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,269,168.48	7,174,939.94
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>00.00</u>	<u>675,000.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	675,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	675,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	675,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	675,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>00.00</u>	<u>-675,000.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /	
					Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	352,432,470.00	845,181,603.80	-139,701,938.39	00.00	1,057,912,135.41
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	352,432,470.00	845,181,603.80	-139,701,938.39	00.00	1,057,912,135.41
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-20,771,972.07	00.00	-20,771,972.07
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	402,382,470.00	873,578,150.84	-175,495,330.29	00.00	1,100,465,290.55
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	402,382,470.00	873,578,150.84	-175,495,330.29	00.00	1,100,465,290.55
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	169,064,138.80	00.00	169,064,138.80
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	402,382,470.00	873,578,150.84	-6,431,191.49	00.00	1,269,529,429.35
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-169,064,138.80	00.00	00.00	-169,064,138.80
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	27,912,123.50	00.00	27,912,123.50
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	402,382,470.00	704,514,012.04	21,480,932.01	00.00	1,128,377,414.05

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,742,312.00	4,486,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,742,312.00	4,486,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,407,312.00	3,062,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		178,000.00
210201	Тэтгэврийн даатгал		178,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	376,162.00	204,420.00
210403	Шуудан, холбоо, ингернэтийн төлбөр	71,162.00	24,420.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	305,000.00	180,000.00
2105	Нормативт зардал		389,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		389,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	755,850.00	1,275,580.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		972,000.00
210604	Урсгал засвар	755,850.00	303,580.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,275,300.00	1,014,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,275,300.00	1,014,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,335,000.00	1,424,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,335,000.00	1,424,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,335,000.00	1,424,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,742,312.00	1,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,742,312.00	1,000,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		1,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн уйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,742,312.00	00.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(II)-(I)	-	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүвтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	255,869,600.00	244,662,619.52	253,209,100.00	246,034,160.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	255,869,600.00	244,662,619.52	253,209,100.00	246,034,160.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	255,369,600.00	244,482,619.52	252,792,400.00	245,634,160.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	174,442,800.00	169,840,427.05	174,442,800.00	174,413,940.52
210101	Үндсэн цалин	130,998,300.00	147,230,167.44	130,998,300.00	118,190,446.83
210102	Нэмэгдэл	29,836,500.00	13,306,797.61	29,836,500.00	43,084,493.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,608,000.00	9,303,462.00	13,608,000.00	13,139,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,549,900.00	21,488,945.01	23,549,800.00	22,812,087.54
210201	Тэтгэврийн даатгал	16,572,100.00	19,230,746.06	16,572,000.00	15,820,231.28
210202	Тэтгэмжийн даатгал	1,744,400.00	564,549.70	1,744,400.00	1,757,414.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,395,500.00	451,639.79	1,395,500.00	1,395,851.20
210204	Ажилгүйдлийн даатгал	348,800.00	112,909.89	348,800.00	348,962.73
210205	Эрүүл мэндийн даатгал	3,489,100.00	1,129,099.57	3,489,100.00	3,489,628.19
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,784,400.00	41,943,321.00	44,784,400.00	39,659,882.00
210301	Гэрэл, цахилгаан	3,773,000.00	3,483,757.00	3,773,000.00	3,275,732.00
210302	Тулш, халаалт	37,888,000.00	37,882,504.00	37,888,000.00	35,112,055.00
210303	Цэвэр, бохир ус	3,123,400.00	577,060.00	3,123,400.00	1,272,095.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,075,300.00	3,051,876.46	1,975,900.00	1,975,900.00
210401	Бичиг хэрэг	1,622,400.00	1,622,064.00	622,400.00	542,600.00
210402	Тэвэр, шатахуун	595,900.00	595,900.00	496,500.00	558,500.00
210403	Шуудан, холбоо, интернэгийн төлбөр	557,000.00	533,912.46	557,000.00	574,800.00
210406	Бага үнэтэй, гүргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	300,000.00	300,000.00	300,000.00	300,000.00
2105	Нормативт зардал	987,000.00	987,000.00	987,000.00	987,000.00
210503	Нормын хувьд, зөөлөн эдлэл	987,000.00	987,000.00	987,000.00	987,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,157,400.00	3,157,400.00	1,666,700.00	1,666,700.00
210604	Урсгал засвар	3,157,400.00	3,157,400.00	1,666,700.00	1,666,700.00
2107	Томилголт, зочны зардал	849,000.00	669,000.00	683,800.00	416,000.00
210702	Дотоод албан томилолт	849,000.00	669,000.00	683,800.00	416,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамт	4,523,800.00	3,344,650.00	4,702,000.00	3,702,650.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	3,552,100.00	2,602,100.00	2,960,100.00	2,960,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	110,700.00	-	110,700.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	50,000.00	50,000.00	50,000.00	50,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	110,700.00	-	110,700.00
210807	Газрын төлбөр	379,000.00	149,850.00	1,149,200.00	149,850.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500,000.00	180,000.00	416,700.00	400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	180,000.00	416,700.00	400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	180,000.00	416,700.00	400,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	255,869,600.00	255,869,600.00	253,209,100.00	253,209,100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	244,662,619.52	244,662,619.52	253,209,100.00	253,209,100.00
132001	Орон нутгийн төсвөөс	244,662,619.52	244,662,619.52	253,209,100.00	253,209,100.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	18	18	17	18
620001	Удирдах ажилтан	1	1	-	1
620002	Гүйцэтгэх ажилтан	7	7	7	7
620003	Үйлчлэх ажилтан	10	10	10	10

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баянжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Музей нь соёлын өвийн үйлчилгээ, хүртээмжийг дээшлүүлж, хүүхэд залуучуудыг эх оронч үзлээр хүмүүжүүлэх, иргэдийн түүх, соёлын өвийн мэдлэгийг дээшлүүлж, өвлөн уламжлуулах, судалгаа, сургалт, сурталчилгааны төв болоход чиглүүлнэ гэж эрхэм зорилгоо тодорхойлсон, Төв аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллага юм.

- Соёлын өвийн хууль, Музейн хууль, Төрийн албаны холбогдох хууль, тогтоомж, дүрэм журмыг хэрэгжүүлэх
- Музейн үзмэр, орон нутаг дахь соёлын өвийн судалгаа хийж, иргэдэд хүргэсэн байх
- Үзүүлэгийг шинжлэх ухааны үндэслэлтэй, уран сайхны аргаар дэглэж, гадаад дотоодод үзэсгэлэн зохион байгуулах замаар соёлын өвийн мэдээллийг шинэ технологи нэвтрүүлэн иргэдэд хүргэх
- Боловсрол, танин мэдэхүйн ажлыг өргөжүүлэн, сургалт сурталчилгааг танхимын болон бусад хэлбэрээр зохион байгуулах
- Соёлын өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж, орчин үеийн тоног төхөөрөмж суурилуулж аюулгүй байдлыг ханган ажиллах
- Стандартад нийцсэн музейн шинэ барилгатай болох
- Музейн удирдлага, албан хаагчдын манлайлах чадварыг хөгжүүлж боловсон хүчнийг чадавхжуулах
- Соёлын өвийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй гадаад, дотоодын байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлж, туршлага солилцох, аж ахуйн нэгж байгууллагын хамтын ажиллагааг идэвхжүүлэх
- Санхүү эдийн засгийг чадавхжуулах, соёлын өвийн хамгаалалтыг сайжруулах төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх

- Ажиллагсдын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд ажилтан бүрд бодитой туслалцаа дэмжлэг үзүүлэх

гэсэн 11 чиглэлээр 42 үйл ажиллагааг 80.49 хувиар хэрэгжүүлж, В үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Музейн дотоод хяналтын зөвлөл нь 2019 оны А/14 дүгээр тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан. Дотоод хяналтын зөвлөл нь улирал бүр удирдамж гарган түүнийхээ дагуу ажилладаг.

Төв аймгийн Музейн дотоод аудитын чиг үүрэг, түүний үйл ажиллагааг аймгийн Санхүү хяналт, аудитын алба гүйцэтгэдэг. 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй талаар ойлголт олж авснаар дотоод аудитын ажлыг аудитад ашиглахгүй гэж шийдвэрлэсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Музей нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 1,5 хувиар буюу 4,176.5 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг тогтоох хувийг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3,132.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд сонгосон материаллаг байдлын суурь үзүүлэлт, материаллаг байдлын түвшин, гүйцэтгэлийн материаллаг байдлын хувийг өөрчлөхгүйгээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт зардлаас 1.5 хувиар буюу 4,874.7 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг тогтоосон материаллаг байдлын 75 хувиар буюу 3,656.1 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин шинэчлэн тогтоосон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 523.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Музей нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Соёлын тухай хууль, Музейн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны санхүүгийн байдал, үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бэлтгэн тайлагнасан байна.

Санхүүгийн “ аcolous ” программыг ашиглаж нягтлан бодох бүртгэлийг хөтөлж байна.

Орлого:

Төв аймгийн Музей нь 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайланд орон нутгийн төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилт 253,209.1 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 98,442.3 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Боловсролын газраас үзэсгэлэн гаргахаар 1,000.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 3,426.0 мянган төгрөг, нийт үйл ажиллагааны орлогыг 356,137.4 мянган төгрөгөөр, мөнгөн гүйлгээний тайланд орон нутгийн төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилт 253,209.1 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд боловсролын газраас 1,000.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 4,426.0 мянган төгрөг, нийт үйл ажиллагааны мөнгөн орлогыг 257,695.1 мянган төгрөгөөр тайлагнасан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн Боловсролын газраас боловсролын 100 жилийн ойн арга хэмжээнд үзэсгэлэн дэглэн гаргах зориулалттай 1,000.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 3,426.0 мянган төгрөг орлогоор бүртгэгдсэн байна.

Зардал:

Төв аймгийн Музей нь 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар 324,982.5 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 257,020.1 мянган төгрөгөөр тайлагнасан байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:

Тус байгууллага төрийн сангийн 100140035010 тоот дансанд 253,209.1 мянган төгрөгийн орлого, 253,209.1 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна. Мөн нэмэлт санхүүжилтийн 100140035402 тоот дансанд 4,486.0 мянган төгрөгийн орлого, 4,486.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж үлдэгдэл 0 төгрөг байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 1,564,946.2 мянган төгрөг, тайлант онд улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй хүлээж авсан хөрөнгийн орлого 96,952.3 мянган төгрөг, өөрийн орлогын бүрдэлтээс тоос сорогч, камерын хяналтын дэлгэц 675.0 мянган төгрөгөөр худалдан авсан байна.

Төв аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 62 дугаар тогтоолоор актлахаар шийдвэрлэгдсэн /2009 онд ашиглалтад орсон 4,561.1 мянган төгрөгийн дансны үнэтэй, 1,368.3 мянган төгрөгийн элэгдэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхөөгүй, 3,192.8 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй/ хөрөнгийг данснаас хасаж, үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,658,012.3 мянган төгрөг болсон байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 26,419.5 мянган төгрөг, тайлант онд худалдаж авсан 6,900.5 мянган төгрөг, Хөгжлийн бодлогын хэлтсийн соёлын цаг хөтөлбөрөөс санхүүжүүлсэн 1,440.0 мянган төгрөгийн үзүүлэнгийн самбарууд, ОБГ-с 50.0 мянган төгрөгийн маскийг үнэ төлбөргүй хүлээн авч, нийт 8,390.5 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, тайлант онд зарцуулсан 8,898.9 мянган төгрөгийн бараа материалыг зарлага болгож, бараа материалын эцсийн үлдэгдэл 25,911.1 мянган төгрөг байна.

Авлага, өглөгийн талаар:

Тайлант жилийн авлагын данс эхний үлдэгдэл 0 төгрөг, нэмэгдсэн 1,219.9 мянган төгрөг, хасагдсан 1,219.9 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 0 төгрөг байна.

Өглөгийн данс эхний үлдэгдэл 0 төгрөг, нэмэгдсэн 284,303.6 мянган төгрөг, хасагдсан 284,303.6 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 0 төгрөг байна.

Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч 10 байгууллагуудтай тооцооны дансдын үлдэгдлийг тооцоо нийлсэн баримтаар баталгаажуулсан байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн данс, арилжааны банкны харилцах данс үлдэгдэлгүй байна. Бараа материал 25,911.1 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 1,102,466.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	26,419.5	25,911.1	-508.4
Үндсэн хөрөнгө	1,074,045.8	1,102,466.3	28,420.5
Нийт хөрөнгө	1,100,465.3	1,128,377.4	27,912.1
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,100,465.3	1,128,377.4	27,912.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,100,465.3	1,128,377.4	27,912.1

Бараа материалын дансны үлдэгдэл 25,911.1 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 508.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,102,466.3 мянган төгрөг болж 28,420.5 мянган төгрөгөөр өсөхөд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Манзушир дахь салбар Байгалийн болон Шашны музейн гадна орчны тохижилт, түүх соёлын үл хөдлөх хөшөө дурсгалын хадгалалт хамгаалалтыг сайжруулахад 60,000.0 мянган төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Музейн барилгын дулааны шугамыг иж бүрэн солих 31,048.6 мянган төгрөгийн хөрөнгө сайжруулалтаар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 66,014.1 мянган төгрөг, данснаас хасагдсан хөрөнгийн элэгдэл 1,368.3 мянган төгрөг байна.

Цэвэр хөрөнгө, өмчийн дүн 1,128,377.4 мянган төгрөг болж, 27,912.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд орон нутгийн төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 278,956.8 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 4,500.0 мянган төгрөг, нийт урсгал зардалд 283,456.8 мянган төгрөг төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн шууд захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 30,247.7 мянган төгрөгөөр бууруулан орон нутгийн төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 253,209.1 мянган төгрөг, урсгал зардлыг 253,209.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилд музей нь Ковид-19 цар тахлын хөл хорио цээрийн үед үндсэн үйл ажиллагааг хэвийн явагдах хүртэл төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөөгүй байсан.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар орон нутгийн төсвөөс 253,209.1 мянган төгрөгийн санхүүжилт бүрэн авч, 246,034.2 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 7,174.9 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт урсгал зардлын гүйцэтгэл 246,034.2 мянган төгрөг буюу 97.2 хувьтай зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Музейн төслийн багаас Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтран Манзушир дахь салбар Байгалийн болон Шашны музейн гадна орчны тохижилт, түүх соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтыг сайжруулах 60,000.0 мянган төгрөгийн өртөгтэй төслийг бичиж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн.

Уг ажлыг гүйцэтгэгчээр “Пластик центр” ХХК тендерт шалгарч Манзушир дахь машины зогсоолын доод талд Эко нойл, хогийн сав, зогсоолоос Байгалийн музей хүртэл явган хүний зам, гэрэлтүүлэг, сандал, сүүдрэвч, музейн гадна талд байрлах түүх соёлын үл хөдлөх хөшөө дурсгалуудад хайс, тайлбар самбар хийх зэрэг ажлыг гүйцэтгүүлсэн байна.

Музейн барилгын дулааны шугамыг иж бүрэн солих 31,048.6 мянган төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн төсвөөс шийдүүлж, сантехникийн ажлын тендерт Цогт-Өлзийт ХХК шалгарч, гүйцэтгэсэн байна.

Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” заалтын дагуу тооцоолоход 1,043.2 мянган төгрөгийн зардлыг хэмнэж болох байсан ч, тухайн байгууллагын удирдлага шийдвэр гаргаж ажилтнууддаа түлээ нүүрсний хөнгөлөлтөд 1,424.0 мянган төгрөг, тусгай хэрэгсэлд 297.0 мянган төгрөг, ажлын хувцаст 445.0 мянган төгрөг, нийт 2,166.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлсийн 2018-2019 оны улсын тооллогоор музейн сахиул П.Дэмбэрэлмоломын хариуцсан Төв аймгийн музейн Манзушир дахь шашны салбар музейгээс дутаасан 89-1467 хувийн дугаартай чавир, ТӨМ86.0.1 хувийн дугаартай дамар зэрэг 2 дугаар дэсийн 2ширхэг үзмэрийг дутаасан байна.

Түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлсийн улсын тооллогын комисс / аймгийн БСУГ-ын дарга, музейн захирал, аймгийн МХГ-ын боловсрол, соёлын улсын байцаагч, ЗДТГ-ын НБХ-ийн дарга, НБХ-ийн соёлын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, музейн аргазүйч, сан хөмрөгийн эрхлэгч, музейн бүртгэл мэдээллийн санч нар/ 2019 оны 3 дугаар сарын 28-ны өдөр үзмэр дутсаныг илрүүлж, 2019 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр энэхүү дутагдсан үзмэр, эд өлгийн зүйлсийг жагсаалт үйлдэн, Соёлын өвийн үндэсний төвийн захирал Г.Энхбатад утсаар мэдэгдсэн боловч, цагдаагийн газарт мэдэгдээгүй байна.

Манзушир дахь Шашны салбар музейгээс дутагдсан 2 ширхэг үзмэрийг байгууллагын даргын 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/27 дугаар тушаалын дагуу хохирлыг барагдуулж, сахиул П.Дэмбэрэлмоломын 2,700.0 мянган төгрөгөөр худалдан авсан эд өлгийн зүйлсийг 2021 оны 01 дүгээр сарын 12-нд үнэ тогтоон орлого авч орлуулсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллийг хуулийн хугацаанд нь 148 мэдээлэл байршуулж, 1 мэдээлэл хугацаа хоцроож 99.3 хувьтай хэрэгжүүлсэн байна. Хугацаа нь болоогүй 2 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-д “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх” зарчмуудыг хангаж, холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлж, Төв аймгийн Музейн 2021 оны 6 дугаар сарын 11-ний 37 тоот албан бичгээр Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Музейн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлс, үзмэр үзүүллэгүүдэд тавих дотоод хяналтыг сайжруулж, дэвшилтэт техник технологийг ашиглан камержуулсан эсэхийг дараагийн аудитаар анхаарах асуудлаар тодорхойлж, байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 39,151.7 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, 38,314.8 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 836.9 мянган төгрөгийн материаллаг бус 2 зөрчилд зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Төсвийн гүйцэтгэлийн тайланд нийт зардлыг болон санхүүжилтийн эх үүсвэрийг татан төвлөрүүлсэн 7,174.9 мянган төгрөгөөр тохируулга хийгээгүй, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 31,089.9 мянган төгрөгийн барилга, байгууламжийн сайжруулалтыг үндсэн хөрөнгийн тодруулгад худалдаж авсан байдлаар тайлагнасан, нийт 38,264.8 мянган төгрөгийн алдаатай тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” - ын 8 дугаар заалтыг болон санхүүгийн тайлангийн “оршин байх”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

ОБГ-с үнэ төлбөргүй ирсэн 500 ширхэг 50.0 мянган төгрөгийн маскийг тулган баталгаажуулалт хийхэд бараа материалын дансанд орлого авалгүй шууд үнэ төлбөргүй зардалд бичсэн бөгөөд “Ковид-19” цар тахлын үед ажилтнууддаа жагсаалтын дагуу зарлага болгож данс бүртгэлд тусгаагүй алдаа байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Худалдан авалттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Худалдан авалтыг е баримтаар баталгаажуулсныг тулгалт хийхэд, 3 байгууллагатай 436.9 мянган төгрөгийн гүйлгээг баримтжуулаагүй зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “НХМаягт ТМ-5 ebarimt -нд үндэслэн бүх төрлийн санхүүгийн гүйлгээг хийж албан ёсны анхан шатны баримтаар бүрдүүлээгүй” гэсэнтэй нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бүх төрлийн санхүүгийн гүйлгээг хийж албан ёсны анхан шатны баримтаар бүрэн бүрдүүлж байх

2. Дотоод хяналттай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

2018-2019 оны улсын тооллогоор Манзушир дахь Шашны салбар музейгээс дутагдсан 2 ширхэг үзмэрийг байгууллагын даргын 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/27 дугаар тушаалын дагуу 2021 оны 01 дүгээр сарын 12-нд үнэ тогтоон орлого авч орлуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.”, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.5-д “соёлын биет өв алдагдсан, үрэгдсэн тохиолдолд тухайн шатны бүртгэл, мэдээллийн сан, Засаг дарга, цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэх” гэсэнтэй нийцэхгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал”, “Эрх ба үүрэг”, “Бодитой оршин байх ба тодорхойлогдсон байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Манзушир дахь Шашны салбар музейн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлс, үзмэр үзүүллэгүүдэд тавих дотоод хяналтыг сайжруулж, дэвшилтэт техник технологийг ашиглан камержуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д /д	Аудитад хамрагдсан байгууллаг ын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрий н акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Музей	5	39,151.7	3	38,314. 8	0	0.0	0	0.0	2	836.9

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70272287
И-мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn